

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн нэмэлт санхүүжилтийн төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СНАГ-2025/108/НА-СТА-ТХН

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2025 он	Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.
	<b>Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг</b> Утас: 261663, Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn <b>Аудитын менежер: П.Чанцалдулам</b> Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn <b>Аудитор: Г.Тэлмүүн</b> Утас: 261740 Цахим хаяг: telmuung@audit.gov.mn <b>Эйч Эл Би Монголиа Аудит ХХК-ийн захирал: Ч.Энхтуяа</b> Утас: 99110581 Цахим хаяг: enkhtuya@hlb.mn

**АГУУЛГА**

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....2

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....5

    2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....5

    2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....6

    2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....8

    2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан..... 10

    2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....11

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....13

    Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл ..... 13

    Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 14



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

ХИЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ  
БҮС НУТГИЙН НЭМЭЛТ  
САНХҮҮЖИЛТИЙН ТӨСЛИЙН  
ЗОХИЦУУЛАГЧ Д.БАТТӨР ТАНАА

2025.04.17 № 07/1505  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн нэмэлт санхүүжилтийн төслийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дараах зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тушаал шийдвэргүйгээр 98,591.6 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлсэн, авто тээврийн хэрэгслийн гэрчилгээг шилжүүлээгүй;
- Гэрээний ерөнхий нөхцөлийн дагуу суутгасан 226,036.3 мянган төгрөгийн барьцаа хөрөнгийг гүйцэтгэгч компанийн хүсэлтээр чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө чөлөөлсөн;
- Бичигт хилийн боомтын авто замын барилга угсралтын ажлыг гүйцэтгүүлэхээр "Хурдны Зам" ХХК, "Нэг Шугам" ХХК-иудын түншлэлтэй 2023 онд БА-5 дугаартай 15,308,622.6 мянган төгрөгийн гэрээ байгуулсан боловч ажил гүйцэтгэх хугацаа хоцрогдолтой бөгөөд 2,711,926.7 мянган төгрөгийн гүйцэтгэлд хяналт тавьж, ажлын фото зураг, ил далд ажлын актыг баталгаажуулалгүйгээр 2,342,203.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон;
- Бичигт хилийн боомт орчимд 2023 оны 7 дугаар сарын 14, 16, 24-ний өдрүүдэд үер буусны улмаас "Хурдны Зам" ХХК-ийн гүйцэтгэсэн газар шорооны ажил сүйдэж

хохирлын хэмжээг "Хурдны Зам" ХХК-ийн зүгээс 239,451.9 мянган төгрөгөөр тодорхойлсны дагуу хохирлын хэмжээг магадлашгүй ажлын нөөц хөрөнгөөс санхүүжүүлж, захиалагчийн зүгээс газар дээр нь хэмжилт хийж тодорхойлоогүй, хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.19, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6, Барилгын төсөв зохиох дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4, Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 2 дугаар зүйлийн 2.1.6, 2.3, 5 дугаар зүйлийн 5.1-т заасантай тус тус нийцээгүй бөгөөд иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Азийн хөгжлийн банкны санхүүгийн дэмжлэгтэй хэрэгжиж буй Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн нэмэлт санхүүжилтийн төслийн нийт санхүүжилт 29.78 сая ам.доллар, гүйцэтгэл өссөн дүнгээр 11.0 сая ам.доллар буюу 36.9 хувийн ашиглалттай байна. Үүнээс тайлант онд 2.2 сая ам.долларын санхүүжилт авсан байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Боомтын сэргээлтийн үндэсний хорооны даргын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 02/1337 дугаар тушаалаар Бичигт хилийн боомтын барилга угсралтын ажлыг гүйцэтгэж байсан "Хилийн цэргийн 0119 дүгээр анги" ТӨХК-д гэрээний 75.1-д заасан үндэслэлээр гэрээг цуцлах албан бичиг хүргүүлсэн байна. Уг гэрээ цуцлагдвал 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгон төслийн зээлийг хаах байсан хугацааг сунгаж болзошгүй нөхцөл үүссэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>26,170,790,954.95</b>	<b>29,432,816,998.13</b>
<b>31</b>	<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>	<b>4,966,277,398.52</b>	<b>2,298,430,462.96</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>4,966,277,398.52</b>	<b>2,298,430,462.96</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>9,548,054.37</b>	<b>24,505,535.92</b>
31211	Төрийн сангийн харилцах	9,548,054.37	24,505,535.92
<b>3122</b>	<b>Гадаад валютаар</b>	<b>4,956,729,344.15</b>	<b>2,273,924,927.04</b>
31221	Төрийн сангийн харилцах	4,956,729,344.15	2,273,924,927.04
31223	Арилжааны банкин дахь харилцах	-	-
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>1,460,550.00</b>	<b>956,710.00</b>
34600	Урьдчилж гарсан зардал	1,460,550.00	956,710.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>620,129.58</b>	<b>862,886.85</b>
354	Хангамжийн материал	620,129.58	862,886.85
35410	Бичиг хэргийн материал	488,727.23	450,000.00
35440	Түлш шатах тослох материал	131,402.35	412,886.85
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	<b>21,202,432,876.85</b>	<b>27,132,566,938.32</b>
36800	Бусад эргэлтийн хөрөнгө	21,202,432,876.85	27,132,566,938.32
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>114,469,092.26</b>	<b>3,480,759.88</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>114,469,092.26</b>	<b>3,480,759.88</b>
392	Биет хөрөнгө	114,469,092.26	3,480,759.88
39203	Авто тээврийн хэрэгсэл	171,463,636.30	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	(64,298,863.80)	-
39205	Машин, тоног төхөөрөмж	23,362,999.50	23,362,999.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(18,732,866.46)	(22,205,466.54)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,509,600.00	3,509,600.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(835,413.28)	(1,186,373.08)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>26,285,260,047.21</b>	<b>29,436,297,758.01</b>
	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	-	<b>15,352,756.22</b>
	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>15,352,756.22</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	<b>15,352,756.22</b>
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	<b>15,352,756.22</b>
<b>41361</b>	<b>Байгууллагад төлөх өглөг</b>	-	<b>15,352,756.22</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>26,285,260,047.21</b>	<b>29,420,945,001.79</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>26,285,260,047.21</b>	<b>29,420,945,001.79</b>
512	Хуримтлагдсан үр дүн	26,285,260,047.21	29,420,945,001.79
51210	Өмнөх үеийн үр дүн	22,941,609,178.78	26,285,260,047.21
51220	Тайлант үеийн үр дүн	3,343,650,868.43	3,135,684,954.58
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>26,285,260,047.21</b>	<b>29,436,297,758.01</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,082,711,520.26</b>	<b>8,330,707,832.13</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,082,711,520.26</b>	<b>8,330,707,832.13</b>
120	Нийтлэг татварын бус орлого	4,082,711,520.26	8,330,707,832.13
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	4,078,493,741.08	8,329,094,832.13
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	3,706,150,241.60	6,932,260,848.65
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	372,343,499.48	1,396,833,983.48
120009	Бусад орлого	4,217,779.18	1,613,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>699,035,734.17</b>	<b>5,093,549,129.73</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>699,035,734.17</b>	<b>799,580,526.63</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>699,035,734.17</b>	<b>799,580,526.63</b>
<b>2101</b>	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>361,800,800.35</b>	<b>375,259,810.20</b>
210101	Цалин	361,800,800.35	375,259,810.20
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>45,225,099.99</b>	<b>46,944,513.53</b>
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	45,225,099.99	46,944,513.53
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой зардал</b>	<b>81,540,000.00</b>	<b>78,570,990.00</b>
210304	Байрны түрээс	81,540,000.00	78,570,990.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>8,119,584.83</b>	<b>14,111,866.99</b>
210401	Бичиг хэргийн материал	1,921,643.15	2,694,302.69
210402	Тээвэр, шатахууны зардал	-	4,033,000.50
210403	Шуудан холбоо интернэтийн төлбөр	5,532,659.86	5,435,713.80
210404	Ном, хэвлэлийн зардал	294,000.00	-
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	371,281.82	1,948,850.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,871,568.02</b>	<b>2,449,540.91</b>
210604	Урсгал засвар	9,871,568.02	2,449,540.91
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>31,120,806.9</b>	<b>40,368,746.71</b>
210702	Дотоод томилолтын зардал	31,120,806.9	40,368,746.71
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>138,538,430.50</b>	<b>229,478,316.57</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	106,239,130.50	196,478,316.57
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	31,900,000.00	33,000,000.00
210803	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	399,300.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>22,819,443.58</b>	<b>12,396,741.72</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,819,443.58	12,396,741.72
<b>28</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>4,293,968,603.10</b>
	Дотоод эх үүсвэрээр	-	4,293,968,603.10
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал	-	4,293,968,603.10

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)</b>	<b>3,383,675,786.09</b>	<b>3,237,158,702.40</b>
145	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>201,898,294.76</b>	<b>45,855,120.07</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	201,898,294.76	45,855,120.07
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>241,923,212.42</b>	<b>147,328,867.89</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	98,591,590.66
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	241,923,212.42	48,737,277.23
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)</b>	<b>(40,024,917.66)</b>	<b>(101,473,747.82)</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)</b>	<b>3,343,650,868.43</b>	<b>3,135,684,954.58</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,707,356,320.78</b>	<b>6,932,660,848.65</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,707,356,320.78</b>	<b>6,932,660,848.65</b>
120	Нийтлэг татварын бус орлого	3,707,356,320.78	6,932,660,848.65
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	3,706,150,241.60	6,932,260,848.65
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	3,706,150,241.60	6,932,260,848.65
120009	Бусад орлого	1,206,079.18	400,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>657,095,224.55</b>	<b>771,762,053.02</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>657,095,224.55</b>	<b>771,762,053.02</b>
<b>210</b>	<b>БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>657,095,224.55</b>	<b>771,762,053.02</b>
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	361,800,800.35	375,259,810.20
210101	Үндсэн цалин	361,800,800.35	375,259,810.20
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>45,225,099.99</b>	<b>46,944,513.53</b>
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	45,225,099.99	46,944,513.53
<b>2103</b>	<b>Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал</b>	<b>71,127,272.76</b>	<b>71,427,272.76</b>
210304	Байрны түрээс	71,127,272.76	71,427,272.76
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,484,390.29</b>	<b>11,646,771.69</b>
210401	Бичиг хэрэг	2,194,568.58	2,397,445.45
210402	Тээвэр, шатахуун	-	2,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,954,730.89	4,947,976.24
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	335,090.82	1,901,350.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,887,359.36</b>	<b>2,271,227.27</b>
210604	Урсгал засвар	8,887,359.36	2,271,227.27
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>24,728,325.00</b>	<b>39,672,880.00</b>
210702	Дотоод албан томилолт	24,728,325.00	39,672,880.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>134,841,976.80</b>	<b>224,539,577.57</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	105,478,976.80	194,539,577.57
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	29,000,000.00	30,000,000.00
210803	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	363,000.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>3,050,261,096.23</b>	<b>6,160,898,795.63</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>4,103,743,916.65</b>	<b>8,825,863,574.03</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4,103,743,916.65</b>	<b>8,825,863,574.03</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>4,103,743,916.65</b>	<b>8,825,863,574.03</b>

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
220001	Барилга байгууламж	4,103,743,916.65	4,849,375,531.41
222001	Тоног төхөөрөмж	-	3,976,488,042.62
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(4,103,743,916.65)</b>	<b>(8,825,863,574.03)</b>
14	Бусад эх үүсвэр	<b>201,898,294.76</b>	<b>45,855,120.07</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	201,898,294.76	45,855,120.07
<b>25</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны зардал</b>	<b>241,923,212.42</b>	<b>48,737,277.23</b>
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	241,923,212.42	48,737,277.23
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>(40,024,917.66)</b>	<b>(2,882,157.16)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(1,093,507,738.08)</b>	<b>(2,667,846,935.56)</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,059,785,136.60	4,966,277,398.52
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>4,966,277,398.52</b>	<b>2,298,430,462.95</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

*/төгрөгөөр/*

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>22,941,609,178.78</b>	<b>22,941,609,178.78</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	22,941,609,178.78	22,941,609,178.78
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-		
Тайлант үеийн үр дүн	-	-	3,343,650,868.43	3,343,650,868.43
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>26,285,260,047.21</b>	<b>26,285,260,047.21</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	<b>26,285,260,047.21</b>	<b>26,285,260,047.21</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-		
Тайлант үеийн үр дүн	-	-	3,135,684,954.58	3,135,684,954.58
<b>2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	-	-	<b>29,420,945,001.79</b>	<b>29,420,945,001.79</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>9,631,100,000.00</b>	<b>9,597,625,627.05</b>	<b>33,474,372.95</b>	<b>99.7</b>
<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>781,100,000.00</b>	<b>771,762,053.02</b>	<b>9,337,946.98</b>	<b>98.8</b>
Бараа, үйлчилгээний зардал	781,100,000.00	771,762,053.02	9,337,946.98	98.8
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>376,000,000.00</b>	<b>375,259,810.20</b>	<b>740,189.80</b>	<b>99.8</b>
Үндсэн цалин	376,000,000.00	375,259,810.20	740,189.80	99.8
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>53,200,000.00</b>	<b>46,944,513.53</b>	<b>6,255,486.47</b>	<b>88.2</b>
Тэтгэврийн даатгал	53,200,000.00	46,944,513.53	6,255,486.47	88.2
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>71,500,000.00</b>	<b>71,427,272.76</b>	<b>72,272.24</b>	<b>99.9</b>
Байрны түрээс	71,500,000.00	71,427,272.76	72,272.24	99.9
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,900,000.00</b>	<b>11,646,771.69</b>	<b>253,228.31</b>	<b>97.9</b>
Бичиг хэрэг	2,400,000.00	2,397,445.45	2,554.55	99.9
Тээвэр (шатахуун)	2,500,000.00	2,400,000.00	100,000.00	96.0
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	5,000,000.00	4,947,976.24	52,023.76	99.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	2,000,000.00	1,901,350.00	98,650.00	95.1
<b>Эд хогшил худалдан авах</b>	<b>2,450,000.00</b>	<b>2,271,227.27</b>	<b>178,772.73</b>	<b>92.7</b>
Урсгал зардал	2,450,000.00	2,271,227.27	178,772.73	92.7
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>40,600,000.00</b>	<b>39,672,880.00</b>	<b>927,120.00</b>	<b>97.7</b>
Дотоод албан томилолт	40,600,000.00	39,672,880.00	927,120.00	97.7
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	<b>225,450,000.00</b>	<b>224,539,577.57</b>	<b>910,422.43</b>	<b>99.6</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	195,100,000.00	194,539,577.57	560,422.43	99.7
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	30,000,000.00	30,000,000.00	-	100.0
Мэдээллийн технологийн зардал	350,000.00	-	350,000.00	-
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>8,850,000,000.00</b>	<b>8,825,863,574.03</b>	<b>24,136,425.97</b>	<b>99.7</b>
<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>8,850,000,000.00</b>	<b>8,825,863,574.03</b>	<b>24,136,425.97</b>	<b>99.7</b>
Барилга байгууламж	4,850,000,000.00	4,849,375,531.41	624,468.59	100.0
Тоног төхөөрөмж	4,000,000,000.00	3,976,488,042.62	23,511,957.38	99.4

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>9,631,100,000.00</b>	<b>6,932,260,848.65</b>		
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>9,631,100,000.00</b>	<b>6,932,260,848.65</b>		
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	9,631,100,000.00	6,932,260,848.65		
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>4,966,277,398.52</b>		
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>2,298,430,462.95</b>		
Төсвийн тохируулга		(2,482,157.17)		
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>		
Төсвийн байгууллага	1	1		
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>11</b>	<b>7</b>	<b>4</b>	<b>63.6</b>
Удирдах ажилтан				
Гүйцэтгэх ажилтан	11	7	4	63.6

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТӨБЗГ-ын тушаал шийдвэргүйгээр авто тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлсэн байна. Гэвч авто тээврийн хэрэгслийн гэрчилгээ тус ТХН-ийн нэр дээр бүртгэлтэй байна.	1	98,591.6	-	-	1	98,591.6	-	-	-	-	-	-
2	Боршоо хилийн боомтын авто зам, инженерийн шугам, сүлжээний угсралтын ажлыг гүйцэтгүүлэхээр "Сайн Констракшн" ХХК, "Тотал Инж" ХХК, "Сан" ХХК-иудын түншлэлтэй 2020 оны 07 дугаар сарын 17-ны өдөр БА-8 дугаартай 9,610,667.6 мянган төгрөгийн дүнтэй гэрээ байгуулж, ажлыг 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр улсын комисст хүлээлгэн өгсөн байна. Гэрээний ерөнхий нөхцөлийн дагуу суутгасан 452,078.7 мянган төгрөгийн барьцаа хөрөнгийг гүйцэтгэгч компанийн хүсэлтээр чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө чөлөөлсөн байна. Чанарын баталгаат хугацаа 1,095 хоног буюу 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрөөр дуусгавар болно.	1	226,036.3	1	226,036.3	-	-	-	-	-	-	-	-
3	Бичигт хилийн боомтын авто замын барилга угсралтын ажлыг гүйцэтгүүлэхээр "Хурдны Зам" ХХК, "Нэг Шугам" ХХК-иудын түншлэлтэй 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр БА-5 дугаартай 15,308,622.6 мянган төгрөгийн дүнтэй гэрээ байгуулсан байна. Ажил гүйцэтгэх хугацаа хоцрогдолтой бөгөөд 2,711,926.7 мянган төгрөгийн гүйцэтгэлд хяналт тавьж, ажлын фото зураг, ил далд ажлын актыг баталгаажуулалгүйгээр 2,342,203.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.	1	2,342,203.0	-	-	1	2,342,203.0	-	-	-	-	-	-

**Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн нэмэлт санхүүжилтийн төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

4	Бичигт хилийн боомт орчимд 2023 оны 7 дугаар сарын 14, 16, 24-ний өдрүүдэд үер буусны улмаас "Хурдны Зам" ХХК-ийн гүйцэтгэсэн газар шорооны ажил сүйдэж хохирлын хэмжээг "Хурдны Зам" ХХК-ийн зүгээс 239,453.8 мянган төгрөгөөр тодорхойлсны дагуу хохирлын хэмжээг магадлашгүй ажлын нөөц хөрөнгөөс санхүүжүүлж, захиалагчийн зүгээс газар дээр нь хэмжилт хийж тодорхойлоогүй, хяналт тавьж ажиллаагүй байна.	1	239,451.9	-	-	1	239,451.9	-	-	-	-	-
<b>Дүн</b>		<b>4</b>	<b>2,906,282.8</b>	<b>1</b>	<b>226,036.3</b>	<b>3</b>	<b>2,680,246.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

*/мянган төгрөгөөр/*

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Бусад хууль, тогтоомж зөрчсөн асуудал</b>									
1	Алтанбулаг, Боршоо, Сүхбаатар хилийн боомтуудад теле хяналтын систем нийлүүлэх ажлыг гүйцэтгүүлэхээр "Арш Технологи" ХХК, "Тотал Технологи" ХХК-иудын түншлэлтэй 2023 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр Б-15 дугаартай 2,899,486.3 мянган төгрөгийн дүнтэй гэрээ байгуулсан байна. Гэрээнд 5 нэр төрлийн 250 ширхэг хяналтын камер дагалдах сервер, компьютер болон бусад тоног төхөөрөмжийн хамт нийлүүлэхээр зааж, тоног төхөөрөмжийг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр хүлээн авч, 2,885,529.3 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Гэвч тус компанитай ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг компаниудаас үнийн судалгаа авч харьцуулахад зах зээлийн үнээс өндөр үнээр худалдан авалт хийсэн байна.	1	-	-	-	1	-	-	-
<b>Дүн</b>		<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>